



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН  
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

# ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

*MONTHLY BULLETIN OF STATISTICS*

2016/5



[www.nso.mn](http://www.nso.mn) [govisumber.nso.mn](http://govisumber.nso.mn) [www.1212.mn](http://www.1212.mn)



**www.1212.mn**



**СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЛИЙН  
НЭГДСЭН САН**



www.nso.mn сайтын  
**Хэрэглэгийн бүртгэлд**  
бүртгүүлснээр  
цахим хаягаар  
тогтмол авч болно.



**Monstat ezStat**  
аппликейшн



**1900-1212**



Лавлах утас

**Үндэсний  
Статистикийн  
хорооны  
НОМЫН САН**

@statistic\_mn



Статистик  
мэдээлэл



Онлайн лавлах  
мессенжер  
8:30-17:30

# СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЭЛ

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭГ

ХҮНД СУРТАЛ  
АВЛИГА

ҮГҮЙ

НЭЭЛТТЭЙ

ХҮРГЭНЭ



## ГАРЧИГ

- Ерөнхий тэмдэглэл .....
- Аргачлалын тайлбар.....
- I.Нийгмийн байдал.....
- II. Нийгмийн даатгал, халамж.....
- III.Эрүүл мэнд .....
- IV.Гэмт хэрэг .....
- V.Үнэ.....
- VI.Төсөв.....
- VII.Хөдөө аж ахуй .....
- VIII. Аж үйлдвэр .....
- IXI.Тээвэр.....
- XI. Холбоо.....
- XII.Цаг агаарын мэдээ.....
- Хавсралт.....



## Ерөнхий тэмдэглэл

### I. Товчилсон тэмдэглэл:

Сумдын нэр:

СҮ Сүмбэр

БТ Баянтал

ШГ Шивээговь

### II. Саруудыг ром тоогоор тэмдэглэв. (I, II, III, IV, V, VI ...г.м)

Тухай сарыг оруулсан жилийн эхнээс өсөн нэмэгдэх дүнг харуулахдаа I-IV, I-XII зэргээр илэрхийлэв.

### III. Дараах тэмдэглэлийг ашиглав:

... Мэдээлэл байхгүй

0.0 Маш бага тоо+, - Зөрүү

- Гүйцэтгэл байхгүй\* Дахин

"Үүнээс" гэдгийг харуулах бөгөөд зарим тохиолдолд тухайн үзүүлэлтийн бүрэлдэхүүн хэсгүүдийн нийлбэр нэгдсэн дүнтэй тэнцэхгүй байж болно.

## АРГАЧЛАЛЫН ТАЙЛБАР

### • Хөдөлмөр:

Бүртгэлтэй ажилгүй иргэдэд Монгол Улсын хуулиар зөвшөөрөгдсөн хөдөлмөрлөх насны, хөдөлмөр эрхлэх чадвартай, цалин хөлстэй ажил болон хувиараа хөдөлмөр эрхэлдэггүй, тухайн үед ажиллахад бэлэн, цалин хөлстэй ажил идэвхтэй хайж байгаа Хөдөлмөрийн хэлтэст бүртгүүлсэн хүмүүс орсон болно.

### • Нийгмийн даатгал, халамж:

✓ Нийгмийн даатгалын сан нь ажил олгогч, даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогоос тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, үйлчилгээнд зарцуулах болон нийгмийн даатгалын үйл ажиллагааны зардлыг нөхөх зорилгоор төлсөн шимтгэлийн орлого, бусад эх үүсвэрээс бүрдэнэ. Нийгмийн даатгалын тухай хууль болон гэрээний үндсэн дээр нийгмийн даатгалын санд нийгмийн даатгалын шимтгэл төлж даатгуулсан, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх бүхий этгээдийг даатгуулагчаар тооцно.



✓ Тэтгэмж нь хөдөлмөрийн чадвараа түр алдах, жирэмслэх, амаржих, нас барах тохиолдолд даатгуулагчийн нийгмийн даатгалын сангаас нэг удаа олгох мөнгөн хөрөнгө байна. Нийгмийн халамжийн дэмжлэг туслалцаа шаардлагатай хүнд хуульд заасан тэтгэвэр, нөхцөлт мөнгөн тэтгэмж олгох, олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн болон төрөлжсөн болон төрөлжсөн асрамжийн үйлчилгээ, үзүүлэх үйл ажиллагааг нийгмийн халамж гэнэ.

- **Эрүүл мэнд**

Жирэмслэлтийн хугацаанаас хамаарахгүйгээр ердийн төрөлтөөр эсвэл мэс ажилбараар ургийг умайнаас гарган авсны дараа нярай амьсгалж байсан, эсвэл амьдын бусад ямар нэгэн шинж тэмдэг, өөрөөр хэлбэл, зүрхний цохилт, хүйний судасны лугшилт, булчингийн тодорхой хөдөлгөөн илэрч байвал хүй эсвэл эхэсийг салгасан эсэхийг харгалзахгүйгээр амьд төрөлтөнд тооцно.

✓ **1 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг** 1 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.

✓ **1-5 хүртэлх насны 1000 хүүхдэд ногдох нялхсын эндэгдлийг** 1-5 хүртэлх насандаа эндсэн хүүхдийн тоог дээрх хугацаанд амьд төрсөн хүүхдийн тоонд харьцуулж тодорхойлдог.

- **Гэмт хэрэг:**

Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан, нийгэмд аюултай гэм буруутай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэг гэнэ. Гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэрхэмжээ, оногдуулж болох ялын хүнд, хөнгөнийг харгалзан гэмт хэргийг хөнгөн, хүндэвтэр, хүнд, онц хүнд гэж ангилна.

Эрүүгийн хууль шинэчлэгдсэнтэй холбогдон гэмт хэргийн нэр төрөл урьдынхаас нилээд өөрчлөгдсөн.

✓ Хүний амь бие, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэгт бусдыг амиа хорлоход хүргэх, иргэдийн эрх чөлөө, эрүүл мэндийн эсрэг гэмт хэрэг болон хүнийг санаатай алах, болгоомжгүйгээс алах хэргий гнэгтгэн оруулсан.

✓ Хүүхэд гэр бүл, нийгмийн ёс суртахууны эсрэг гэмт хэрэгт хүчингийн хэргийг оруулсан.

✓ Өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэгт бусдын эд хөрөнгийг хулгайлах, бусдын эд хөрөнгийг булаах, бусдын эд хөрөнгийг дээрэмдэх, бусдын эд хөрөнгийг залилан мэхэлж авах, бусдын эд хөрөнгийг завших, үрэгдүүлэх гэмт хэргийг хамруулсан.



✓ Байгаль хамгаалах журмын эсрэг гэмт хэрэгт гал түймрийн хэргийг хамруулсан.

✓ Нийгмийн аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт танхайн гэмт хэргийг оруулсан.

- **Үнэ**

Хэрэглээний үнийн индекс /ХҮИ/ нь хэрэглэгчийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрөл, чанар өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмжих үзүүлэлт бөгөөд нийт өрхөөр тооцсон үнийн өөрчлөлтийг харуулна.

Үндэсний статистикийн хороо нь хэрэглээний үнийн улсын индексийг Улаанбаатар хотын ХҮИ-ээр тооцож байсан аргачлалаа шинэчилж, 2008 оны 1 дүгээр сараас олон улсын нийтлэг арга зүйн дагуу хэрэглээний үнийн улсын индексийг аймаг, нийслэлийн өрхийн 2010 оны хэрэглээний зардлаар жигнэсэн дундаж үзүүлэлтээр тооцох аргачлалд шилжсэн.

- **Төсөв санхүү:**

Аймгийн төсвийн мэдээг Санхүү Төрийн сангийн Хэлтэс үндсэн нэгжүүдээс авч нэгтгэн ирүүлдэг.

- **Хөдөө аж ахуй:**

Мал төллөлт, төл бойжилт, мал хорогдлын мэдээг багийн Засаг дарга нар хариуцан цуглуулж, сумын тамгын газарт нэгтгэн ирүүлдэг.

✓ Төл бойжилтын хувийг тооцохдоо бойжсон төлийн тоог нийт гарсан төлийн тоонд харьцуулж, 100-гаар үржүүлнэ.

✓ Зүй бусаар хорогдсон малын тоонд халдвартай, халдваргүй өвчин, зуд, үер ус, гал түймэр, аянга цахилгаан зэрэг гэнэтийн аюул зэрэг хариулга, маллагаатай холбоотой бусад шалтгаанаар хорогдсон малыг хамруулна.

- **Аж үйлдвэр:**

Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл нь аж ахуйн нэгжүүдийн тайлант хугацаанд зах зээлд болон өөрийн эцсийн хэрэглээнд зориулж үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээс бүрдэнэ.

Аж үйлдвэрийн салбарын борлуулсан бүтээгдэхүүн нь аж ахуйн нэгжүүдийн тайлант хугацаанд худалдсан буюу гадагш гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний хэмжээ юм.

Аж ахуйн нэгжүүдийг эдийн засгийн үйл ажиллагаагаар ангилахдаа НҮБ-ын эдийн засгийн үйл ажиллагааны Олон улсын стандарт ангиллыг мөрдөж байна.



## Говьсүмбэр аймгийн нийгэм, эдийн засгийн байдал

(2016 оны 5 дугаар сарын байдлаар)



### I. Нийгмийн байдал

#### I.1 Бүртгэлтэй ажилгүй иргэн


Хөдөлмөрийн хэлтэст бүртгүүлсэн ажил хайгч ажилгүй иргэдийн тоо 2016 оны 5 дугаар сард 303 байгаагийн 170 нь эмэгтэйчүүд байна. Ажил хайгч ажилгүй иргэдийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 72 буюу 23.8 хувиар өсч, өмнөх сарынхаас 45 буюу 12.9 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Эхний 5 сарын байдлаар Хөдөлмөрийн хэлтэст 70 ажлын байрны захиалга ирсэн нь өмнөх оны мөн үеэс 37 буюу 52.8 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Хөдөлмөрийн хэлтсээр эхний 5 сард 25 иргэн ажилд зуучлуулсны 17 нь буюу 68.0 хувь эмэгтэйчүүд байлаа.

Зураг.I.1

Хөдөлмөрийн хэлтэст бүртгүүлсэн ажил хайгч иргэн, үүнээс эмэгтэй,  
жил бүрийн эхний 5 дугаар сарын байдлаар



Ажил хайгч иргэдийн 52.2 хувийг бүрэн дунд, 13.7 хувийг дипломын болон бакалаврын, 12.1 хувийг техникийн болон мэргэжлийн, 9.3 хувийг тусгай мэргэжлийн дунд, 7.0 хувийг суурь, 3.7 хувийг бага боловсролтой, 2.0 хувийг боловсролгүй иргэд эзэлж байна.



## I.2 Ердийн хөдөлгөөн


Улсын бүртгэл, статистикийн газрын Бүртгэлийн хэлтсийн мэдээгээр 2016 оны эхний 5 дугаар сарын байдлаар 183 эх амаржиж, 184 хүүхэд төрсөн нь өмнөх оны мөн үеийнхээс амаржсан эхийн тоо 13 буюу 7.1 хувиар, төрсөн хүүхдийн тоо 13 буюу 7.0 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

Мөн нас баралт 42, бүртгүүлсэн гэр бүл 31, цуцалсан гэр бүл 9, үрчлэгдсэн хүүхэд 3 байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс нас баралт 7 буюу 20.0 хувиар, бүртгүүлсэн гэр бүл 1 буюу 3.3 хувиар тус тус өсч, цуцалсан гэр бүлийн тоо өмнөх оны мөн үетэй ижил төвшинд, үрчлэгдсэн хүүхдийн тоо өмнөх оны мөн үеийнхээс 1 буюу 25.0 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Тайлант хугацаанд 424 иргэн нийслэл болон бусад аймгуудаас шилжин ирж, 288 иргэн нийслэл болон бусад аймаг руу шилжин явсан байна. Өмнөх оны мөн үеийнхээс шилжин ирсэн иргэн 162 буюу 61.8 хувиар, шилжин явсан иргэн 100 буюу 53.2 хувиар тус тус өссөн байна.

Зураг.1.3

Шинэ төрсөн хүүхдийн тоо, жил бүрийн эхний 5 сарын байдлаар



## II. Нийгмийн даатгал, халамж

### II.1 Нийгмийн даатгал

Нийгмийн даатгалын сангийн орлого 2016 оны эхний 5 дугаар сард 2745.0 сая төгрөг, зарлага 3576.9 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс орлого 433.6 сая төгрөг буюу 13.6 хувиар буурч, зарлага 45.5 сая төгрөг буюу 1.3 хувиар өслөө.

Нийгмийн даатгалын сангийн орлого 2016 оны эхний 5 дугаар сард өмнөх оны мөн үеийнхээс 433.6 сая төгрөгөөр буурахад тэтгэврийн орлого 280.9 сая төгрөг буюу 14.1 хувиар буурсан нь голлон нөлөөлсөн байна.





Нийгмийн даатгалын сангийн зарлага 2016 оны эхний 5 дугаар сард 3576.9 болж, өмнөх оны мөн үеийнхээс 45.4 сая төгрөгөөр өсөхөд тэтгэврийн даатгалын сангийн зарлага 161.9 сая төгрөг буюу 6.5 хувиар өссөн нь голлон нөлөөлөв.

## II.2 Нийгмийн халамж

Нийгмийн халамжийн сангаас 2016 оны эхний 5 сард 3412 хүнд 563.3 сая төгрөгийн нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлсэн бөгөөд өмнөх оны мөн үеийнхээс нийгмийн халамж авагчдын тоо 161 хүн буюу 4.9 хувиар, олгосон нийгмийн халамжийн сан 1.9 сая төгрөг буюу 0.3 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.

✓ Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжид 2016 оны эхний 5 сард 1066 хүн хамрагдсан нь өмнөх оны мөн үеийнхээс 87 хүн буюу 7.5 хувиар, олгосон тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээ 11.6 сая төгрөг буюу 3.7 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

✓ Нийгмийн халамжийн үйлчилгээ хөнгөлөлт, тусламжид 2016 оны эхний 5 сард 2346 хүн хамрагдсан нь өмнөх оны мөн үеийнхээс 248 хүн буюу 11.8 хувиар өссөн, олгосон халамж үйлчилгээ хөнгөлөлт, тусламж 13.5 сая төгрөг буюу 5.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна.


## II.3 Дундаж цалин

Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн эхний 5 сарын мэдээгээр 181 байгууллагын 4921 даатгуулагч иргэн, үүнээс 823 нь сайн дурын даатгуулагч байна. Нийт даатгуулагчдын цалин өссөн дүнгээр 15429.5 тэрбум төгрөг байгаа бол сарын дундаж цалин сайн дурын даатгуулагч ороогүй дүнгээр 8309.6 мянган төгрөг байна.

Ажиллагсдын цалинг аж ахуйн нэгж байгууллагын хариуцлагын хэлбэрээр авч үзвэл төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой 21 аж ахуй нэгж, байгууллагын 1128 ажилтны дундаж цалин нь 938.8 мянган төгрөг, төсөвт 54 байгууллагын 1524 ажилтны дундаж цалин нь 679.4 мянган төгрөг, 7 ХКомпанийн 617 ажилтны дундаж цалин нь 815.9 мянган төгрөг, 78 ХХКомпанийн 757 ажилтны цалин дундаж цалин нь 399.1 мянган төгрөг, бусад 21 байгууллагын 147 ажилтны дундаж цалин нь 423.1 мянган төгрөг боллоо.



Нийгмийн даатгалын даатгуулагчийн тоо, 2016 оны эхний 5 дугаар сарын байдлаар




### III. Эрүүл мэнд



Эрүүл мэндийн газраас эрхлэн гаргадаг мэдээгээр 2016 оны эхний 5 сарын байдлаар 186 эх амаржиж, амьд төрсөн хүүхэд 185 үүнээс 84 нь хүү, 101 нь охин байна. Өмнөх оны мөн үеийнхээс амаржсан эх 16 буюу 9.4 хувиар, төрсөн хүүхэд 17 буюу 10.1 хувиар тус тус өссөн байна.

Зураг III.1 Амаржсан эх, амьд төрсөн хүүхэд, жил бүрийн эхний 5 сарын байдлаар




0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 6 ба 1000 амьд төрөлтөд 32.4 ногдож байгаа нь өмнөх оны мөн үеэс 14.5 промилоор нэмэгдсэн, 1-5 хүртэл насны хүүхдийн эндэгдэл 1 тохиолдол бүртгэгдсэн байна /2015 онд 0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 3 ба 1000 амьд төрөлтөд 30.9 промил, 1-5 насанд эндэгдэл, эндэгдэл бүртгэгдээгүй/ 2016 оны 5-р сард гэрийн төрөлт 1 бүртгэгдсэн байна. Халдварт өвчин эхний 5 сарын байдлаар 163



буюу 10000 хүн амд 101.2 байгаа нь өмнөх оны мөн үеэс 109 тохиолдлоор нэмэгдэж, нийт өвчлөлд улаан бурхан өвчин 118 тохиолдол буюу нийт өвчлөлийн 72.4 хувийг эзэлж байна. /2015 онд халдварт өвчлөл 54 гарсан байна.

Зураг III.2

Нас баралт, жил бүрийн эхний 5 сарын байдлаар




Он гарсаар 60734 хүнд амбулаторийн үзлэг хийсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 14581 буюу 31.6 хувиар, 2234 хүн эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 357 буюу 19.0 хувиар тус тус өссөн байна.

2016 оны эхний 5 сарын байдлаар түргэн тусламжийн дуудлага 3130 удаа гарч, осол гэмтлийн өвчлөл 368, халдварт өвчин 163 бүртгэгдсэн байна.

Зураг III.3

Осол гэмтлийн болон халдварт өвчний өвчлөл,  
жил бүрийн эхний 5 сарын байдлаар






#### IV. Гэмт хэрэг

Аймгийн Цагдаагийн хэлтсийн мэдээгээр 2016 оны эхний 5 сард 91 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 4 буюу 4.6 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Зураг IV.1

Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо,  
жил бүрийн эхний 5 сарын байдлаар




Өмнөх оны мөн үеийнхээс нийт гэмт хэргийн тоо өсөхөд өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг 2 буюу 6.4 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Илрээгүй гэмт хэргийн тоо 16, гэмт хэрэг илрүүлэлтийн хувь 67 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс илрээгүй гэмт хэрэг 8 буюу 33.3 хувиар буурсан, илрүүлэлтийн хувь 23.0 пунктээр өссөн үзүүлэлттэй байна.

Гэмт хэргийн улмаас 53 хүн гэмтэж, 2 хүн нас барсан нь өмнөх оны мөн үеийнхээс гэмтсэн хүний тоо 4 буюу 8.2 хувиар өссөн, нас баралт 1 буюу 33.3 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Зураг IV.2

Гэмт хэргийн ангилал,  
жил бүрийн эхний 5 сарын байдлаар






Гэмт хэргийн улмаас учирсан хохирол 2016 оны 5 сарын байдлаар 131.0 сая төг, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 71.0 сая төг болж, өмнөх оны мөн үеийнхээс учирсан хохирлын хэмжээ 514.0 сая төгрөг буюу 79.7 хувь, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 118.0 сая төгрөг буюу 62.5 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

2016 оны эхний 5 сард 349 хүн эрүүлжүүлэгдэж, 8 хүн баривчлагдсан нь өмнөх оны мөн үеийнхээс эрүүлжүүлэгдсэн хүний тоо 77 буюу 18.1 хувь, баривчлагдсан хүний тоо 57 буюу 87.7 хувиар тус тус буурсан байна.

Зураг IV.3

Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан хүний тоо  
жил бүрийн эхний 5 сарын байдлаар



### Хэрэглээний үнийн индекс

Хэрэглээний үнийн индекс гэдэг нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрлөөр өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмждэг үзүүлэлт юм.

Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ аймгийн хэмжээнд 2016 оны 5 дугаар сард өмнөх сарынхаас 5.9 хувь, өмнөх оны эцсийнхээс 3.0 хувь, өмнөх оны мөн үеийнхээс 0.8 хувиар өссөн байна.




## Хэрэглээний үнийн индекс, 2016 оны 5 дугаар сард, бүлгийн дүнгээр

| Бараа үйлчилгээний бүлэг                    | 2016.V | 2016.V   | 2016.V  |
|---|--------|----------|---------|
|   | 2015.V | 2015.XII | 2016.IV |
| Ерөнхий индекс                              | 105.9  | 103.0    | 100.8   |
| Хүнсний бараа, ундаа, ус                    | 102.1  | 109.1    | 100.4   |
| Согтууруулах ундаа, тамхи                   | 97.7   | 100.3    | 100.0   |
| Хувцас, бөс бараа, гутал                    | 112.1  | 101.6    | 101.6   |
| Орон сууц, ус, цахилгаан, түлш              | 100.6  | 97.7     | 99.8    |
| Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа          | 102.4  | 100.0    | 100.1   |
| Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ              | 105.9  | 102.5    | 102.5   |
| Тээвэр                                      | 98.2   | 97.6     | 99.9    |
| Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ     | 100.3  | 100.0    | 100.0   |
| Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ | 102.7  | 102.6    | 100.0   |
| Боловсролын үйлчилгээ                       | 132.5  | 100.0    | 100.0   |
| Зочид буудал, нийтийн хоол, дотуур байр     | 140.2  | 124.9    | 111.6   |
| Бусад бараа, үйлчилгээ                      | 104.6  | 101.1    | 100.3   |

Ерөнхий индекс өмнөх оны мөн үеийнхээс 5.9 хувиар өсөхөд боловсролын үйлчилгээ 32.5 хувиар, зочид буудал, нийтийн хоол, дотуур байрны бүлгийн үнэ 40.2 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ.

## Хэрэглээний үнийн индекс, 2016 оны 5 дугаар сар, (өмнөх сар=100%)





## VI. Орон нутгийн төсөв


2016 оны эхний 5 сарын байдлаар орон нутгийн төсвийн нийт орлогын төлөвлөгөө 6417.8 сая төгрөг, гүйцэтгэлээр 6816.7 сая төгрөг болж нь өмнөх оны мөн үеийнхээс төсвийн орлогын гүйцэтгэл 1957.1 сая төгрөг буюу 40.3 хувиар өсчээ.

Аймгийн төсвийн нийт зарлага 6643.9 сая төгрөг төлөвлөгдсөнөөс 6410.4 сая төгрөгийн гүйцэтгэлтэй 233.6 сая төгрөгийн хэмнэлттэй байна. Төсвийн нийт зарлага өмнөх оны мөн үеийнхээс 1614.3 сая төгрөг буюу 33.6 хувиар өссөн байна.

2016 оны эхний 5 сарын байдлаар авлагын үлдэгдэл 25.0 сая төгрөг, өглөгийн үлдэгдэл 442.2 сая төгрөг байна.

Зураг VI.1

Орон нутгийн төсвийн орлого, зарлага, жил бүрийн  
эхний 5 сарын байдлаар, сая төгрөгөөр



## VII. Мал аж ахуй


Аймгийн хэмжээнд 2015 оны эцэст тоологдсон төллөх насны нийт 171188 хээлэгч малын 148358 буюу 86.6 хувь нь 2016 оны 5 дугаар сарын байдлаар төллөсөн байна. Эм хонины 90.9 хувь, эм ямаа 85.8 хувь, үнээний 70.1 хувь, ингэний 43.2 хувь, гүүний 56.8 хувь нь төллөжээ. Гарсан төлийн 149539 толгой төл бойжиж байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 20698 толгойгоор өссөн үзүүлэлттэй байна.

2016 оны эхний 5 сард том малын зүй бус хорогдол 10943 болж, өмнөх оны мөн үеийнхээс 10633 толгойгоор өссөн байна. Нийт хорогдолд өвчнөөр хорогдсон 2 мал байна.




Зураг VII.1

## Төл бойжилт, жил бүрийн эхний 5 сараар, толгойгоор



Зураг VII.2

## Хорогдсон хээлтэгч, жил бүрийн эхний 5 сараар, толгойгоор

**VIII. Аж үйлдвэр**


Аж үйлдвэрийн салбарын нийт гаргалт 2016 оны эхний 5 сард 18833.6 сая төгрөг болж, өмнөх оны мөн үеийнхээс 4518.9 сая төгрөг буюу 31.6 хувиар өссөн ба үүнд уул уурхайн салбарынх 4482.3 сая төг буюу 33.7 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна. Оны үнээр 18178.5 сая төгрөгийн борлуулалт хийгдсэн нь өмнөх оны мөн үеийнхээс 1227.4 сая төгрөг буюу 7.2 хувиар өслөө.

Шивээ-Овоо ХК нь нийт борлуулалтын 17135.5 сая төг буюу 94.3 хувийг дангаараа бүрдүүлсэн байна.





Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, салбараар,  
жил бүрийн эхний 5 сар, сая төгрөгөөр



### IX.ТЭЭВЭР

Авто тээврийн газар 2016 оны эхний 5 сарын мэдээгээр 9.8 мянган зорчигч тээвэрлэж, зорчигч эргэлт 2135.2 мян.хүн км болж , 14 ажилтантай 5036.9 сая төгрөгийн орлоготой ажилласан байна.


### X. ХОЛБОО

Аймгийн холбооны газрын мэдээгээр 2016 оны эхний 5 сарын байдлаар нийт орлого 85072.0 сая төгрөг болж өмнөх оны мөн үеийнхээс 12.1 сая төг буюу 12.5 хувиар буурчээ. Нийт орлогод хүн амаас орсон орлого 51401.0 сая төг буюу 60.4 хувийг эзэлж, өмнөх оны мөн үеийнхээс 6.8 сая төг буюу 11.8 хувиар буурсан байна. Аймгийн хэмжээнд нийт суурин телефон цэгийн тоо 364 болж өмнөх оны мөн үеийнхээс 45 буюу 11.0 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

2016 оны эхний 5 сарын байдлаар интернэт үйлчилгээний цэгийн тоо 1 байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 1 дахин багассан үзүүлэлттэй байна. Интернэт үйлчилгээний цэгээр үйлчлүүлэгчийн тоо 25 үүнээс байнгын хэрэглэгчийн тоо 8 байна.



Холбооны нийт орлого, үүнээс хүн амаас орсон орлого,  
жил бүрийн эхний 5 сар, сая төгрөгөөр



### XI. Цаг агаарын мэдээ

2016 оны 5 дугаар сард 3.1 мм тунадас орж, ихэнх хугацаанд салхи секундэд 5-10 метр байсан ба хамгийн их нь 12-14 м/с хүрсэн. Агаарын температурын хувьд 5 дугаар сарын нэгдүгээр арав хоногтоо шөнөдөө 4 градус дулаан, өдөртөө 10-15 градус дулаан, хоёрдугаар арав хоногтоо шөнөдөө 3-8 градус, өдөртөө 20-25 градус дулаан, нэг ба хоёрдугаар арав хоногийн зарим өдөр шөнөдөө 5 градус хүйтэн, өдөртөө 20-29 градус дулаан байсан ба гуравдугаар арав хоногтоо шөнөдөө 2-7 градус, өдөртөө 23-28 градус дулаан байсан. Хамгийн их хүйтэн нь 5-р сарын 12-нд 5.2 градус, хамгийн их дулаан нь 5-р сарын 18-нд 29.4 градус дулаан байжээ.

### 2016 оны 06-р сарын агаарын температурын урьдчилсан мэдээ

Энэ сарын агаарын дундаж температур Говьсүмбэр аймгийн нутгаар 18-23 градус дулаан буюу олон жилийн дунджийн орчим байна.

Нэгдүгээр арав хоногийн эхээр шөнөдөө 3-8 градус өдөртөө 14-19 градус дулаан байна. Хоёрдугаар арав хоногийн дунд үе гуравдугаар арав хоногийн эхээр бага зэрэг сэрүүсч шөнөдөө 8-13 өдөртөө 21-26 градус дулаан байна. Бусад хугацаанд шөнөдөө 12-17 градус дулаан өдөртөө 24-29 градус дулаан байх ба ялангуяа нэгдүгээр арав хоногийн сүүлийн хагаст өдөртөө 30-35 градус хүрч халах төлөвтэй байна.

### 2016 оны 06 сарын хур тунадасны урьдчилсан мэдээ

Энэ сард Говьсүмбэр аймгийн нутгаар олон жилийн дунджийн орчим хур тунадас орох төлөвтэй. Нэг ба хоёрдугаар арав хоногийн эхэн ба дунд үеэр гуравдугаар арав хоногийн ихэнх хугацаанд түр зуурын бороо орно. Дуу цахилгаантай. Бороо хур орох үеүдэд салхи



түр зуур ширүүснэ. Ялангуяа хоёр ба гуравдугаар арав хоногийн эхэн ба дунд үеэр дуу цахилгааны үед түр зуур 18-20 м/с хүртэл ширүүсч болзошгүй.

### **ХАА-н үйлдвэрлэлд нөлөөлөх тухай**

6 дугаар сарын цаг агаарын урьдчилсан мэдээгээр хур тунадас олон жилийн дунджийн орчим ба түүнээс ахиу орохоор байгаа нь бэлчээрийн ургамлын ургалтанд сайнаар нөлөөлөхөөр байгаа боловч шөнөдөө сэрүүхэн байж, зарим үед хүчтэй шороон шуурга шуурч малын хариулга маллагаанд хүндрэл учруулж болзошгүйг анхаарна уу.



## ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эхний 5 сарын байдлаар

|  | Хэмжих<br>нэгж | 2015 V  | 2016 V  | Зөрүү   | $\frac{2016 V}{2015 V} \%$ |
|--|----------------|---------|---------|---------|----------------------------|
| <b>Нийгмийн статистикийн үзүүлэлтүүд</b>         |                |         |         |         |                            |
| Төрсөн хүүхдийн тоо (амьд төрөлт)                | хүн            | 168     | 185     | 17      | 110.1                      |
| Ажил хайгч иргэдийн тоо, 5 дугаар сарын эцэст    | хүн            | 451     | 454     | 3       | 100.7                      |
| Халдварт өвчнөөр өвчлөгчдийн тоо                 | хүн            | 56      | 163     | 107     | 291.0                      |
| Бүртгэгдсэн гэмт хэрэг                           | тоо            | 87      | 91      | 4       | 104.6                      |
| <b>Макро эдийн засгийн статистикийн үзүүлэлт</b> |                |         |         |         |                            |
| Орон нутгийн төсвийн орлого                      | сая.төг        | 4859.7  | 6816.7  | 1957.0  | 140.3                      |
| Татварын орлого                                  | сая.төг        | 1202.8  | 2016.8  | 814.0   | 167.7                      |
| Татварын бус орлого                              | сая.төг        | 92.8    | 147.3   | 54.5    | 158.7                      |
| Хөрөнгийн орлого                                 | сая.төг        | -       | 127.1   | -       | -                          |
| Тусламжийн орлого                                | сая.төг        | 3564.1  | 4570.5  | 1006.4  | 128.2                      |
| Орон нутгийн төсвийн зарлага                     | сая.төг        | 4796.1  | 6410.4  | 1614.3  | 133.7                      |
| Бараа үйлчилгээний зардал                        | сая.төг        | 4196.1  | 5335.3  | 1139.2  | 127.1                      |
| <b>Эдийн засгийн үзүүлэлтүүд</b>                 |                |         |         |         |                            |
| Том малын зүй бусын хорогдол                     | <u>тол</u>     | 310     | 10943   | 10633   | 35 дахин                   |
| - Тэмээ  | <u>тол</u>     | -       | 1       | -       | -                          |
| - Адуу   | <u>тол</u>     | 4       | 292     | 288     | 73 дахин                   |
| - Үхэр   | <u>тол</u>     | 12      | 422     | 410     | <u>35 дахин</u>            |
| - Хонь   | <u>тол</u>     | 109     | 3936    | 3827    | 36 дахин                   |
| - Ямаа   | <u>тол</u>     | 185     | 6292    | 6107    | 34 дахин                   |
| Бойжуулсан төл                                   | <u>тол</u>     | 127564  | 147111  | 19547   | 115.3                      |
| - Тэмээ  | <u>тол</u>     | 149     | 152     | 3       | 102.0                      |
| - Адуу   | <u>тол</u>     | 2670    | 3210    | 540     | 120.2                      |
| - Үхэр   | <u>тол</u>     | 2518    | 3391    | 873     | 134.7                      |
| - Хонь   | <u>тол</u>     | 60445   | 71560   | 11115   | 118.4                      |
| - Ямаа   | <u>тол</u>     | 61782   | 68798   | 7016    | 111.4                      |
| Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний нийт гаргалт        | сая.төг        | 16951.6 | 18833.6 | 1882    | 111.1                      |
| Тээврийн орлого                                  | сая.төг        | 2824.3  | 5036.9  | 2212.6  | 178.3                      |
| Холбооны орлого                                  | сая.төг        | 97181.5 | 85072.0 | 12109.5 | 87.5                       |



## I.1 ШИНЭ АЖЛЫН БАЙРНЫ МЭДЭЭ, жил бүрийн эхний 5 сарын байдлаар

| Үзүүлэлтүүд                    | 2015 V | 2016 V | $\frac{2016 V}{2015 V} \%$ |
|--------------------------------|--------|--------|----------------------------|
| Ажил хайгч <u>иргэнийн</u> тоо | 451    | 454    | 100.7                      |
| Үүнээс эмэгтэй                 | 244    | 257    | 105.3                      |
| Ажлын байрны захиалга          | 107    | 70     | 65.4                       |
| Ажилд <u>жуучлагдсан</u> иргэд | 51     | 25     | 49.0                       |
| Үүнээс эмэгтэй                 | 35     | 17     | 48.6                       |

## II.1 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, төрлөөр, жил бүрийн эхний 5 сарын байдлаар

| Сангийн төрөл                                      | 2015 V        | 2016 V        | $\frac{2016 V}{2015 V} \%$ |
|--|---------------|---------------|----------------------------|
| <b>Нийгмийн даатгалын сангийн орлого, сая.төг</b>  | <b>3178.6</b> | <b>2745.0</b> | <b>86.4</b>                |
| Тэтгэврийн даатгалын сангийн                       | 1989.7        | 1708.8        | 85.9                       |
| Тэтгэмжийн даатгалын сангийн                       | 224.7         | 195.2         | 86.9                       |
| Эрүүл мэндийн даатгалын сангийн                    | 608.0         | 535.3         | 88.0                       |
| <u>ҮОМШӨ</u> *-ний даатгалын сангийн               | 300.5         | 258.0         | 85.9                       |
| <u>Ажилгүйдлын</u> даатгалын сангийн               | 55.6          | 47.8          | 86.0                       |
| <b>Нийгмийн даатгалын сангийн зарлага, сая.төг</b> | <b>3531.4</b> | <b>3576.9</b> | <b>101.3</b>               |
| Тэтгэврийн даатгалын сангийн                       | 2500.3        | 2662.2        | 106.5                      |
| Тэтгэмжийн даатгалын сангийн                       | 250.0         | 207.2         | 82.8                       |
| Эрүүл мэндийн даатгалын сангийн                    | 548.8         | 516.8         | 94.2                       |
| <u>ҮОМШӨ</u> *-ний даатгалын сангийн               | 135.0         | 117.3         | 86.8                       |
| <u>Ажилгүйдлын</u> даатгалын сангийн               | 97.2          | 73.4          | 75.5                       |

Тайлбар: \*ҮОМШӨ –Үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчин



## II.2 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДСАН ХҮН, ОЛГОСОН ТЭТГЭВЭР, 2016 оны 5 дугаар сарын байдлаар, сая төгрөгөөр

| Үзүүлэлт  | 2015 V  |       | 2016 V  |       | $\frac{2016 V}{2015 V} \%$ |       |
|---|---------|-------|---------|-------|----------------------------|-------|
|   | Хүн тоо | Дүн   | Хүн тоо | Дүн   | Хүн тоо                    | Дүн   |
| <b>Нийгмийн халамжийн сангийн дүн</b>                                   | 3251    | 561.4 | 3412    | 563.3 | 104.9                      | 100.3 |
| Нийгмийн халамжийн тэтгэвэр,<br>тэтгэмж                                 | 1153    | 314.6 | 1066    | 303.0 | 92.4                       | 96.3  |
| Халамжийн тэтгэвэр  | 278     | 157.8 | 250     | 151.1 | 89.9                       | 95.7  |
| Нөхцөлт мөнгөн тэтгэмж /<br>Үүнээс: /                                   | 875     | 156.8 | 816     | 151.8 | 93.3                       | 96.8  |
| Жирэмсэн болон нярай,<br>хөхүүл хүүхэдтэй эхчүүдийн<br>тэтгэмж          | 611     | 81.4  | 567     | 85.0  | 92.7                       | 71.2  |
| Ахмад настныг асарч буй<br>иргэний асаргааны тэтгэмж                    | 117     | 27.5  | 109     | 27.6  | 93.2                       | 100.3 |
